

## Сургуулийн ус хангамж, ариун цэвэр, эрүүл ахуйн үнэлгээ-2014 он

Захиалагч:  
Гүйцэтгэгч:

Дэлхийн зөн ОУБ  
НЭМҮТ-ийн Эрүүл ахуй, хүний экологийн сектор

**Үндэслэл.** Дэлхийн зөн Олон улсын байгууллагын (ДЗОУБ) тэргүүлэх чиглэл нь хүн амын эрүүл мэнд болон сайн сайхан байдлыг нэмэгдүүлэх явдал юм. ДЗОУБ нь хүн амд өөрөө өөрсдөдөө туслах боломжийг олгодог ба хүүхдүүд хүн амын нийгмийн эрүүл мэндийн байдлыг тодорхойлогч гол үзүүлэлт болдог учраас хүүхдэд чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг.

Монголын хүүхдийн сургуулийн орчин дахь эрүүл мэндийн нэн шаардлагатай хэрэгцээ дээр үндэслэн “Монголын Сургуулиудын Усан Хангамж, Ариун Цэвэр, Эрүүл Ахуй” төсөл хэрэгжиж байгаа юм. Энэ төсөл нь эрүүл ахуй, ариун цэврийн байдлыг сайжруулах, орон нутгийн хэмжээний шийдвэр гаргахад сургууль, олон нийт, Засгийн газарт дэмжлэг үзүүлдэг.

Сайжруулсан ундны усан хангамж болон ариун цэвэр нь хүүхдийн эрүүл мэндэд нөлөөлөгч хүчин зүйлсийн хамгийн чухал бүрэлдэхүүн хэсэгт тооцогддог. Хөдөөгийн болон амьдралын түвшин доогуур айл өрхүүд ихэвчлэн ариун цэвэр, ундны шаардлага хангаагүй ус хэрэглэж байна. Монголын маш олон хүүхдүүд ундны болон ариун цэврийн шаардлага хангасан ус хэрэглэж чадахгүй байна. Түүнчлэн сургуулиуд шаардлага хангасан ундны усны эх үүсвэргүй байгаа нь хүүхдийн дунд усаар дамжих халдварт өвчин болон уснаас шалтгаалах өвчлөлийг нэмэгдүүлдэг. Өнөөгийн ус, ариун цэврийн хангамжийн байдал нь хүүхдийн эрүүл ахуйн шаардлагыг хангаж чадахгүй байгаагаас гадна цаашид эрүүл ахуйн зөв дадалтай, эерэг зан үйлтэй иргэн болж төлөвшихөд саад учруулж, ирээдүйн хор уршгийг дагуулж байна.

Монголын Сургуулийн Ус Хангамж, Ариун Цэвэр Эрүүл Ахуй Төсөл нь Завхан аймаг (Завхан болон Завхангай), Баянхонгор аймаг (Баянхонгорын 1-р бүсийн хөгжүүлэлтийн хөтөлбөр) болон Баянзүрх дүүрэг (ADP-ийн Амгалан болон Дарь-Эх)-ийн сургуулиудын ариун цэвэр, эрүүл ахуйн байдлыг сайжруулах зорилготой юм. Тиймээс эдгээр аймгийн сургуулиудын ус хангамж ариун цэвэр, эрүүл ахуйн өнөөгийн байдлыг тогтоох суурь судалгааны ажлыг хийж, гүйцэтгэх шаардлагатай байна.

### **Зорилго**

Сургуулийн ус хангамж, ариун цэврийн байгууламжид эрүүл ахуйн үнэлгээ өгөх

### **Зорилт**

1. Сурагчдын ус хангамж, ариун цэврийн талаарх мэдлэг, хандлага, дадлыг үнэлэх
2. Сургуулийн ус хангамж, ариун цэврийн байгууламжийн өнөөгийн байдалд үнэлгээ өгөх
3. Анги танхимын дотоод орчны агаар (агаарын хэм, чийглэг, гэрэлтүүлэг, агаарын хөдөлгөөний хурд)–ын чанарт үнэлгээ өгөх
4. Сурагчдын гарын ариун цэвэр, гар угаах дадалд үнэлгээ өгөх

**Судалгааны хамрах хүрээ, арга зүй.** Судалгаанд Завхан аймгийн Улиастай, Тосонцэнгэл, Шилүүстэй, Отгон сумд, Баянхонгор аймгийн төв, Эрдэнэцогт,

Өлзийт сумд, Улаанбаатар хотын Амгалан, Дарь эхийн нийт 26 сургуулиас санамсаргүй түүвэрлэлтийн аргаар сурагчдыг сонгон хамрууллаа (Хүснэгт 1).

Хүснэгт 1

Судалгаанд хамрагдах сурагчдын тоо

№	Сонгогдсон дүүрэг, аймаг, сум	Сонгогдсон сум, дүүргийн сургуулийн дугаар	Нийт хүүхдийн тоо	Сонгогдсон хүүхдийн тоо	Арчдас авах хүүхдийн тоо
1	Завхан аймаг	Улиастай Чандмань цогцолбор сургууль	1103	55/45	15
		Улиастай 4 дүгээр сургууль	564	28	9
		Улиастай Дэвшлийн сургууль	867	43	14
		Улиастай 3 дугаар сургууль	698	35	11
		Шилүүстэй сургууль	380	19	8
		Отгон сургууль	369	18	8
		Жавхлант сургууль	1287	63 /40	13
		Тосонцэнгэл 1 дүгээр сургууль	941	47/25	8
		Тосонцэнгэл 2 дугаар сургууль	1064	53/25	8
		Их уул сургууль	1244	62 / 40	13
				<b>423/318</b>	<b>107</b>
2	Баянхонгор аймаг	Баянхонгорын Номуундалай сургууль	2001	100/50	16
		Номгон сургууль	2079	103/50	16
		Эрдэм сургууль	1325	66/40	13
		Эрдэнэмандал	1466	73/40	13
		SoogoSeiko	560	28	9
		Цогт эрдэм-Эрдэнэцогт сум	359	18	8
		Сайн Оюут –Өлзийт сум	444	22	7
		Баян –ойт	333	16	5
				<b>426/264</b>	<b>71</b>
3	Улаанбаатар хот	БЗД-ийн 102-р сургууль	1941	97/45	15
		БЗД-ийн 79-р сургууль	2252	112/50	16
		БЗД-ийн 27-р сургууль	2294	114/50	16
		БЗД-ийн 68-р сургууль	1165	58	19
		БЗД-ийн 87-р сургууль	1863	93/45	15
		БЗД-ийн 92-р сургууль	1460	73/50	18
		БЗД-ийн 48-р сургууль	1491	75/50	18
		БЗД-ийн 120-р сургууль	544	27	9
				<b>649/375</b>	<b>126</b>
<b>Нийтдүн</b>			<b>30094</b>	<b>1528/ 957</b>	<b>304</b>

Асуулга судалгаанд хамрагдах сурагчдыг санамсаргүй түүврийн аргаар, ахлах, дунд, бага ангийн ангиллаар, хүйсийн тэнцүү харьцаатайгаар сонгон хамрууллаа. Судалгаанд хурдавчилсан шинжилгээний, ажиглалтын, тооны болон чанарын судалгааны аргуудыг хослуулан ашиглалаа.

Зорилт 1-ын хүрээнд. Сонгогдсон сургуулиудын бага, дунд, ахлах ангийн нийт 957 сурагчаас ус хангамж, ариун цэврийн байгууламжийн талаарх мэдлэг, дадлага, хандлагыг үнэлэх асуумж авлаа. Ус хангамж, ариун цэвэр, эрүүл ахуйн талаарх сурагчдын мэдлэг, хандлага, дадлыг тодорхойлохын тулд асуулга судалгааны аргыг ашиглав.

Судалгааны асуумж нь сургуулийн ерөнхий мэдээлэл болон сурагч нэг бүрийн мэдлэг, хандлагыг тогтоох гэсэн 2 үндсэн бүтэцтэй.

Зорилт 2,3-ын хүрээнд. Судалгаанд хамрагдсан сургуулиудын сурагчдаас бүлгийн ярилцлага, удирдах ажилтнуудаас ганцаарчилсан ярилцлага хийлээ.

Мөн сургуулиудын ус хангамж, ариун цэврийн байгууламжийн (АЦБ) байдал, эрүүл ахуйн нөхцөлд үнэлгээ өгөх зорилгоор хүүхдийн байгуулагуудын эдэлбэр газрын талбайн хэмжээ, усан ханагмж ариун цэврийн байгууламжийн хүртээмж, ашиглалт, анги танхимын бичил цаг уурын үзүүлэлтүүдээр хэмжилт хийж Сургалт-хүмүүжлийн байгууллагын барилга төлөвлөлтийн норм ба дүрэм (БНБД-II-66-88)-д заасан үзүүлэлттэй харьцуулан эрүүл ахуйн үнэлгээ өглөө.

Дээрх үзүүлэлтүүдийг ажиглалтын болон хэмжилтийн аргаар судалж, хэмжилтэнд дотоод орчны агаарын чанарын хэмжилтийн PCE-MLM1(гэрэлтүүлэг), PCE-MHT1(харьцангуй чийглэг), PCE-777(агаарын хэм) багажуудыг ашиглан хэмжлээ.

Зорилт 4-ын хүрээнд. Сонгогдсон аймаг, дүүргийн сургуулиудийн сурагчдын гарын ариун цэвэр, гар угаах дадалд үнэлгээ өгөхийн тулд нийт 296 сурагчийн гарын арчдас авч, гэдэсний бүлгийн савханцар илрүүлэх шинжилгээг хурдавчилсан тестээр хийлээ.

## **1. Тоон судалгааны үр дүн**

### **Ус хангамж, усны хүрэлцээний талаарх сурагчдын мэдлэг, хандлага, дадал**

“Сургууль дээрээ ам цангасан үедээ ус уух боломжтой байдаг уу” гэсэн асуултанд нийт сурагчдын 61 хувь нь сургууль дээрээ ус уух боломжгүй гэж хариулсан нь хүүхдүүд усны дуталд өртөж байгааг харуулж байна. Ангиар авч үзэхэд бага ангийн сурагчдын 47.2 хувь нь сургууль дээр ус уух боломжтой байдаг гэж хариулсан нь дунд, ахлах ангийнхаас 10.6-12.2 хувиар илүү байлаа. Үүнийг бага ангийн сурагчид сургууль дээрээ үдийн цай уудаг, тэр үеэрээ ус юм уудагтайгаа холбон тайлбарлаж байсан юм.

Ундны усыг ихэвчлэн хаанаас авч уудаг талаар тодруулахад судалгаанд хамрагдсан сурагчдын 28.0 хувь нь гэрээсээ авчирдаг, 33.6 хувь нь худалдаж авдаг, 9.8 хувь нь крантнаас, 26.3 хувь нь цэвэр усны аппаратаас уудаг гэсэн бол 2.2 хувь нь дээрх бүх аргуудыг хэрэглэдэг гэж хариулжээ.

Уух усаа худалдаж авдаг гэж хариулсан сурагчдын ихэнх буюу 59.2 хувийг Улаанбаатар хотоос хамрагдсан сурагчид эзэлж байсан бол Завхан аймгийн сурагчид 15.8, Баянхонгор аймгийнх 25 хувийг тус тус эзэлж байлаа. Эндээс харахад Улаанбаатар хотын хүүхдүүд илүү ихээр ус худалдан авдаг нь харагдаж байна.

“Сургууль дээр ангийн чинь болон бусад хүүхдүүд крантны ус уудаг уу” гэсэн асуултанд нийт сурагчдын 66.5 хувь нь огт уудаггүй, 33.5 хувь нь ямар нэгэн байдлаар, тухайлбал хааяадаа, заримдаа эсвэл ихэнх тохиолдолд уудаг гэж хариулсан байна. Судалгаанд хамрагдсан охидын 65.5(61.1-69.9 CI), хөвгүүдийн 67.4(63.1-71.7 CI) хувь нь крантны ус огт уудаггүй гэж хариулснаас үзэхэд хүүхдүүдийн крантны ус ууж байгаа байдал хүйсийн хувьд ялгаагүй байна. Ангиар авч үзэхэд бага ангийн сурагчдын 72.8(67.4-78.2 CI), дунд ангийн 64.7(59.8-69.6 CI), ахлах ангийн 62.7(56.8-68.5 CI) хувь нь тус тус крантны ус уудаггүй гэж

хариулсан байна. Эндээс харахад ахлах ангийн хүүхдүүд бага ангийн ангийнхнаас илүү ихээр крантны ус ууж байгаа ба энэ нь статистикийн магадлал бүхий байв. Крантны ус уух байдал хөдөө орон нутгийн сурагчдын дунд илүү түгээмэл байсан ба крантны ус уудаг гэж хариулсан нийт сурагчдын 83.2 хувь нь хөдөө орон нутгийн сурагчид байна.

### **Сургуулийн ариун цэврийн байгууламжийн ашиглалт**

Судалгаанд хамрагдсан нийт сурагчдын 65.4 (622) хувь нь “сургууль дээрээ шаардлагатай үедээ гар угаагуурыг ашиглаж чаддаг гэж” хариулсан бол 34.6 (329) хувь нь “ашиглаж чаддаггүй” гэсэн байна. Улаанбаатар хотын Дарь-Эх орон нутгийн хөтөлбөрийн сургуулиудын сурагчид сургууль дээрээ гар угаагуурыг бусад сургуулиудын сурагчдаас 1.1-2.3 дахин бага ашиглаж байна.

Ангиар авч үзэхэд бага ангийн сурагчид гар угаагуурыг хамгийн бага ашиглаж байгаа ба энэ нь нийт сурагчдын 5.8 хувь, ашиглаж чаддаггүй нийт сурагчдын 19.4 хувийг эзэлж байна.

Гар угаагуурыг ашиглаж чадахгүй байгаа шалтгааныг тодруулахад “угаагуур ажилладаггүй” шалтгаан 43.5 хувийг эзэлж байсан бол усгүй байдаг 25.8 хувь, саван байдаггүй 15.2 хувь, хүйтэн устай 7.6 хувь, бохир байдаг 4.9 хувь, алчуур болон хатаагч байдаггүй шалтгаан 3.0 хувийг тус тус эзэлж байлаа.

Судалгаанд хамрагдсан хөдөө орон нутгийн сурагчдын 81.2, Улаанбаатар хотын сурагчдын 18.8 хувь нь ус байдаггүйн улмаас гар угаагуурыг ашиглах боломжгүй байдаг гэж хариулсан байна.

“Сургуулийн бие засах газрыг тогтмол, шаардлагатай үедээ ашиглаж чаддаг эсэх”-ийг тодруулахад нийт сурагчдын 770 буюу 91 хувь нь ашиглаж чаддаг гэсэн бол 181 буюу 19 хувь нь ашиглаж чаддаггүй гэжээ.

“Сургуулийн бие засах газрыг тогтмол ашиглаж чадахгүй байгаа” шалтгааныг тодруулахад давхардсан тоогоор сурагчдын 59.7 хувь нь сургуулийн жорлон бохир эвгүй үнэртэй байдаг учраас, 30.4 хувь нь ариун цэврийн цаасгүй байдаг учраас, 18.2 хувь нь гар угаах боломжгүйгээс, 30.4 хувь нь усгүй байдгаас, 25.4 хувь нь гадаа байдаг учир, 63 хувь нь ачаалал ихтэйгээс, 38.7 хувь нь жорлон хүрэлцдэггүйгээс, 19.9 хувь нь бусад шалтгааны улмаас сургуулийн жорлонг тогтмол ашиглаж чаддаггүй гэж тус тус хариулсан байлаа.

“Сургуулийн гар угаагуур байнга устай байдаг эсэх” талаар тодруулахад нийт сурагчдын 2.5 хувь нь огт ус байдаггүй гэсэн бол 97.5 хувь нь ерөнхийдөө устай байдаг гэж хариулсан байна.

“Угаагуурын дэргэд хатуу, шингэн савангийн аль нь байвал илүү тохиромжтой байх” талаарх сурагчдын хандлагыг тодруулахад судалгаанд хамрагдсан нийт сурагчдын 385(40.5) хувь нь хатуу, 566 (59.5) хувь нь шингэн байх нь зүгээр гэж хариулжээ. Хөвгүүдийн 58.0(53.5-62.5CI), охидын 61.0 (56.6-65.4CI) хувь нь хатуу саван байх нь тохиромжтой гэж үзсэн байна. Эндээс харахад охид, хөвгүүдийн хувьд ялгаагаагүй хатуу саван байхыг илүүд үзэж байна.

“Угаагуурын дэргэд саван байдаг уу” гэсэн асуултанд нийт сурагчдын 63.4% (60.3-66.5CI) хувь нь огт байдаггүй гэж хариулсан нь сурагчид гараа савандаж угаах боломж хангагдаагүй байгааг харуулж байна. ОНХХ тус бүрээр авч үзвэл Завханы сургуулийн сурагчдын 45.2% (38.0-52.4CI), Завхангайн 52.7% (43.9-61.4CI), Баянхонгорын 68.1% (62.4-73.8CI), Улаанбаатар хотын Дарь-эхийн 64.1%

(56.2-72.0CI), Амгалангийн 78.6%(73.2-83.9 CI) хувь нь тус тус угаагуурын дэргэд саван байдаггүй гэж хариулсан байна.

“Сургууль дээрээ гараа угаахдаа саван хэрэглэдэг эсэх” талаар тодруулахад нийт сурагчдын 57.8 хувь нь огт хэрэглэдэггүй, 12.9 хувь нь тогтмол хэрэглэдэг гэж хариулсан бол ерөнхийдөө саванг ховор ба заримдаа л хэрэглэдэг гэж хариулсан хүүхдийн эзлэх хувь 34.2 байлаа. Гараа угаахдаа саван огт хэрэглэдэггүй нийт 550 хүүхдийн дотор бага ангийн сурагчдын эзлэх хувь хамгийн бага буюу 16.9 хувь байна.

Сургууль дээрээ гараа угаахдаа саван хэрэглэхгүй байгаа шалтгаануудыг авч үзэхэд сургуульд саван байдаггүй гэж нийт сурагчдын 69.2 хувь нь хариулсан ба энэ нь хамгийн түгээмэл шалтгаан болж байгаа нь харагдаж байна (Дүрслэл 2). Нийт сурагчдын 17.1 хувь буюу 142 нь бусад шалтгааны улмаас гараа угаахдаа саван хэрэглэдэггүй гэж хариулсан байсан ба үүний 50-60 хувийг усгүй ба угаагуургүй гэсэн шалтгаан эзэлж байлаа.

Сургууль дээрээ сурагчдын 47.9 хувь нь нойтон, 0.7 хувь нь хуурай салфетка, 1.6 хувь гар ариутгагч ашигладаг, 15.4 хувь нь савандаж, 20.7 хувь нь зүгээр л усаар, 6.4 хувь нь бусад өөр аргуудыг ашиглан гараа угаадаг гэсэн бол 7.3 хувь нь гараа огт угаадаггүй гэж хариулсан байлаа.

Сурагчид сургууль дээрээ гараа угаахдаа ихэнх тохиолдолд нойтон салфетка хэрэглэж байсан ба энэ байдал хөтөлбөрийн хэрэгжилтийн орон нутгуудад ерөнхийдөө ойролцоо түвшинд байна.

Хөдөө орон нутгийн хүүхдүүдийн 82.6 хувь, хотын хүүхдүүдийн 12.6 хувь нь сургууль дээрээ гараа угаадаггүй байна.

Судалгаанд хамрагдсан нийт сурагчдын 58.5 (556) хувь нь багш нарын бие засах газар тусдаа, 41.5 (395) хувь нь тусдаа биш, хамт байдаг гэж хариулсан байлаа.

Хөдөө орон нутгийн сургуулиудын 18.5 хувь, хотын сургуулиудын 54.2 хувьд нь багш сурагчдын бие засах газар тусдаа байдаг байна.

Судалгаанд хамрагдагсдын 32.4 (308) хувь нь бие засах газрын гэрэлтүүлэг хүрэлцээгүй, гэрэл муутай гэж үзэж байлаа. Үүний 82.1 хувь нь хөдөө орон нутгийн сургуулиуд байна. Хөдөө орон нутгийн сургуулиуд ихэвчлэн гадаа бие засах газартай байдагтай холбоотойгоор гэрэлтүүлэг хангалтгүй байна.

### **Гар угаах болон түүний ач холбогдлын талаарх сурагчдын мэдлэг, хандлага**

Гараа хэдийд угаах ёстой байдаг талаарх сурагчдын ойлголтын талаар асууж ярилцахад судалгаанд оролцсон сурагчдын 82.6 (80.2-85.1 CI) хувь нь хоол идэхийн өмнө, 83.7(81.3-86.1 CI) хувь нь өглөө босоод, 54.8 (51.6-58.0 CI) хувь нь бие зассаны дараа, 50.3(47.1-53.4CI) хувь нь унтахын өмнө, 45.7 (42.6-48.9CI) хувь нь гараа бохирдох бүрт угаах ёстой гэж хариулжээ. Харин хичээл хийхийн өмнө болон хичээлээс ирээд, тоглохын өмнө болон тоглосныхоо дараа, ханиаж найтаасны дараах зэрэг тохиолдлуудад гараа угаах ёстой гэсэн мэдлэгтэй сурагчид харьцангуй бага буюу 2.2-37.1 хувийг эзэлж байлаа. Мөн сурагчдын 2.9 хувь нь сайн мэдэхгүй буюу ерөнхийдөө өглөө, оройдоо угаах ёстой гэсэн мэдлэгтэй байгаа нь эдгээр сурагчдын мэдлэгийн түвшин хангалтгүй байгааг харуулж байна.

Унтахын өмнө гараа угаах ёстой гэж хөвгүүд охидоос илүү ихээр үзэж байсан бол бие зассаны дараа болон хоол идэхийн өмнөх тохиолдлуудад гараа угаах ёстой гэж охидууд хөвгүүдээс илүү ихээр үзэж байлаа ( $p < 0.001$ ).

Бие зассаны дараа гараа угаах ёстой гэж судалгаанд хамрагдсан бага ангийн нийт сурагчдын 42.6 (36.8-48.4CI) хувь, дунд ангийн сурагчдын 58.1 (53.2-63.1CI) хувь, ахлах ангийнхны 62.5 (56.8-68.2CI) хувь нь хариулсан. Харин бохирдох бүрт нь угаах ёстой гэж бага ангийнхны 32.7 (27.3-38.2CI), дунд ангийнхны 49.4 (44.4-54.4CI), ахлах ангийнхны 53.9 (48.1-59.8CI) хувь нь хариулжээ. Эндээс харахад бие зассаны дараа болон гараа бохирдох бүрт угаах ёстой талаарх сурагчдын ойлголт статистикийн магадлал бүхий ялгаатай буюу бага ангийн сурагчдын мэдлэгийн түвшин дунд, ахлах ангийн сурагчдынхаас бага байгаа нь харагдаж байна.

Харин хичээл номоо хийхийн өмнө гараа угаах ёстой гэж хариулсан бага ангийн сурагчдын эзлэх хувь (20.3%, 27.3-38.2CI) дунд, ахлах ангийнхнаас илүү их (17.3%, 13.5-21.1CI; 14.3%, 10.2-18.4CI) байгаа нь статистикийн магадлал бүхий байлаа.

Хэдийгээр сурагчид гараа хэдийд угаах талаар тодорхой хэмжээгээр мэдлэгтэй байгаа хэдий ч сурагчдын мэдлэгийн түвшин хүйс, насны бүлэг буюу ангиар ялгаатай байгаа нь харагдаж байна.

Харин бусад тохиолдлуудад сурагчдын мэдлэгийн түвшинд ангиар авч үзэхэд магадлал бүхий ялгаа ажиглагдсангүй.

“Цэвэр гартай байх нь ямар ач холбогдолтой байдаг” талаар тодруулахад нийт сурагчдын 40.7 (37.6-43.8CI) хувь нь халдварт шар өвчнөөс сэргийлнэ, 34.4 (31.4-37.4CI) хувь нь гэдэсний халдвараас сэргийлнэ, 23.3 (20.5-25.9CI) хувь нь бусдад өвчин халдаахгүй, 84.4 (82.1-86.7CI) хувь нь өвдөхгүй эрүүл байна гэсэн бол 3.5 (2.3-4.6CI) хувь нь мэдэхгүй гэж хариулсан байна.

Зөв хариулсан охидын эзлэх хувь хөвгүүдийнхээс их байсан ба өөрөөр хэлбэл цэвэр гарын ач холбогдлын талаар охидууд хөвгүүдээс илүү их мэдээлэлтэй байгаа нь харагдаж байна. Анги ахих тутам зөв хариулж буй сурагчдын эзлэх хувь нэмэгдэж байсан ба өөрөөр хэлбэл сурагчдын нас ахих тутам мэдлэг дээшлэх хандлагатай байна гэж үзэж болох юм.

### **Сурагчдын гараа угааж буй дадал**

“Гэр бүлийнхэн чинь чиний гараа угааж буй эсэхэд анхаарал хандуулдаг уу” гэсэн асуултанд нийт сурагчдын 75.6 хувь нь “тийм, хандуулдаг” гэсэн бол 24.4 хувь нь “үгүй, хандуулдаггүй” гэж хариулсан байна.

Хотын сурагчдын эцэг эхчүүдийн 77.8% (74.4-81.2 CI), хөдөөгийн 72.2% (67.6-76.7 CI) хувь нь хүүхдийнхээ гар угааж буй эсэхэд анхаарал тавьдаг байна. Эндээс харахад эцэг эхчүүдийн хүүхэддээ анхаарал тавих байдал хот, хөдөөд ялгаагүй байна.

Бага ангийн сурагчдын эцэг эхчүүд дунд, ахлах ангийн эцэг эхчүүдээс илүү хүүхэддээ анхаарал тавьдаг байна ( $p < 0.0004$ ).

“Аав нь болон ээж нь ямар ямар тохиолдлуудад гараа угаадаг вэ” гэсэн асуултанд хариулсан сурагчдын эзлэх хувийг дараах дүрслэлээр харуулсан ба унтах, хоол идэх болон бэлтгэхийн өмнө, бие зассаны болон ханиаж найтаасны

дараа, өглөө босоод гэх мэт тохиолдлуудад ээжүүд аавуудаас илүү их гараа угаадаг нь харагдаж байна.

“Гар угаах дараалал болон усны зөв хэрэглээний талаарх зурагт хуудас сургууль дээр байдаг эсэх” талаар тодруулахад судалгаанд хамрагдсан нийт сурагчдын 84.2 (761) хувь нь байдаг гэж хариулсан бол 15.8 (143) хувь нь байдаггүй гэсэн байлаа. Зурагт хуудас байдаггүй гэж хариулсан 143 сурагчийн 65 хувь нь хөдөө орон нутгаас, 35 хувь нь Улаанбаатар хотоос хамрагдсан байлаа. Зурагт хуудас байдаг гэж хариулсан сурагчдын 42.6 хувь нь зурагт хуудсыг хараад л өнгөрдөг, 36.4 хувь нь дотор нь юу бичсэн байгааг уншдаг гэсэн бол 21 хувь нь түүн дээр бичсэн зааврын дагуу гараа угааж, усаа хэмнэж зөв хэрэглэдэг гэж хариулжээ.

Хотын сурагчдын 27.9 (23.7-32.1CI), хөдөөгийн сурагчдын 11.4 (7.8-14.9CI) хувь нь зурагт хуудаст заасны дагуу гараа угааж, усаа зөв хэрэглэдэг гэж хариулсан нь сурагчдын гараа угаах дадал, усны хэрэглээ хот хөдөөгийн сурагчдын хувьд статистикийн магадлал бүхий ялгаатай байгааг харуулж байна.

Судалгаанд хамрагдсан бага ангийн сурагчдын 34.8 (23.7-32.1CI), дунд ангийн сурагчдын 17.9 (13.6-22.2CI), ахлах ангийн сурагчдын 11.7 (18.1-23.9 CI) хувь нь тус тус сургууль дээр байрлуулсан зурагт хуудсан дээрх зааврын дагуу гараа угаадаг гэж хариулсан нь бага ангийн сурагчид дунд, ахлах ангийнхнаас илүү ихээр зурагт хуудсыг ашигладаг болох нь харагдаж байна.

“Гараа хэрхэн угаадаг” талаар тодруулахад судалгаанд хамрагдсан нийт сурагчдын 50.5 хувь нь гар угаах аргыг мэддэг хэдий ч ашигладаггүй, 33.9 хувь нь гараа дарааллын дагуу зөв угаадаг гэсэн бол 15.6 хувь нь гар угаах арга болон дарааллыг мэддэггүй гэж хариулсан байна.

Бага ангийнхны 15.2 (127) хувь, ахлах ангийнхны 5.8 (48) хувь нь нь гараа дарааллын дагуу зөв угаадаг байна.

Гараа зөв угаах арга болон дарааллыг мэддэг хэдий ч ашигладаггүй хүүхдийн эзлэх хувь бага ангийнхны хувьд нийт хүүхдийн 9.7 хувь, ахлах ангийнхны хувьд 19.2 хувь байгаа нь ахлах ангийнхан гар угаах дарааллыг тэр бүр мөрддөггүй болохыг харуулж байна.

Гар угаах дарааллыг бага ангийн сурагчдын 10.7 (6.7-14.7CI), дунд ангийнхны 17.1 (13.1-21.0CI), ахлах ангийнхны 18.1(13.3-22.9CI) хувь нь тус тус мэдэхгүй гэж хариулсан байна.

Сурагчид өглөө босоод, хоол идэхийн өмнө, бие зассаны дараа болон хичээлээс ирсний дараах зэрэг тохиолдлуудад гараа хамгийн их угааж, харин ханиаж найтаасны дараа, ном уншихын өмнө, гадаа тоглосныхоо дараа зэрэг тохиолдлуудад сурагчид гараа бага угаадаг болох нь хөтөлбөрийн орон нутгуудад ойролцоо буюу ижил түвшинд байгаа нь харагдаж байна.

Бага ангийн сурагчдын 37.0 (31.3-42.6CI) хувь нь бие зассаны дараа, 22.9 (18.0-27.8CI) хувь нь гараа бохирох бүрт угаадаг гэж хариулсан нь дунд (46.0%, 41.0-51.0CI; 33.9%,29.1-38.6CI) ахлах ангийнхантай (50.0%, 44.1-55.9CI; 40.0%, 34.2-45.8CI ) харьцуулахад бага байгаа нь статистикийн магадлал бүхий байлаа.

“Сургууль дээрээ гараа тогтмол угаадаг” эсэхийг тодруулахад нийт сурагчдын 44.4 (422) хувь нь огт угаадаггүй, 55.6 (529) хувь нь ямар нэгэн хэмжээгээр гараа угаадаг гэж хариулсан ба гараа тогтмол угаадаг гэж хариулсан хүүхдийн эзлэх хувь 17.5 байгаа нь харьцангуй бага байгааг харуулж байна.

Сургууль дээр гараа тогтмол угаадаг хүүхдийн эзлэх хувь бага ангид хамгийн их (42.3%, 36.5-48.0CI) байсан бол ахлах ангид хамгийн бага (5.0%, 2.4-7.6 CI) байлаа.

Мөн гараа огт угаадаггүй гэж хариулсан хүүхдийн эзлэх хувь бага ангид хамгийн бага (25.0%, 19.9-30.7 CI) буюу дунд, ахлах ангийнхнаас 2 дахин бага байсан ба гараа угаахгүй байгаа байдал нь ангийн хувьд ялгаатай байна.

### **Дүгнэлт**

Сургууль дээрээ 10 хүүхэд тутмын 4 нь ам цангасан үедээ ус ууж чаддаггүй байна. Улаанбаатар хотын сурагчдын  $\frac{1}{2}$  нь уух усаа худалдаж авч уудаг бол хөдөө орон нутагт 10 хүүхдийн 2 нь л ус худалдаж авч уудаг байна. Сурагчдын  $\frac{1}{3}$  нь ам цангасан үедээ сургуулийн крантын түүхий ус ууж байна.

Судалгаанд хамрагдсан нийт сурагчдын 34.6 (329) хувь нь “сургууль дээрээ шаардлагатай үедээ гар угаагуурыг “ашиглаж чаддаггүй” байна. Завхан, Завхангайн сургуулиудад усгүй шалтгаан, харин Баянхонгор болон Улаанбаатар хотын сургуулиудад гар угаагуур ажилладаггүй шалтгаан зонхилж байв.

Нийт сурагчдын  $\frac{1}{3}$  нь гараа дарааллын дагуу зөв угаадаг ба 6 хүүхэд тутмын нэг нь гар угаах арга, дарааллыг мэдэхгүй байна. Бага ангийн сурагчид үдийн цай хөтөлбөрт хамрагдадаг учраас сургууль дээрээ гараа тогтмол угаадаг байдал нь бусад ангийнхнаас харьцангуй их байна.

Ариутгах татуургын сүлжээнд холбогдоогүй сургуулиудын нэг угаагуур, суултуурт ногдох хүүхдийн тоо эрүүл ахуйн шаардлага хангахгүй байна. Энэ нь хүүхдийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж улмаар хүүхдийн байгууллагад гэдэсний болон бусад халдварт өвчин дамжин тархах нөхцлийг бүрдүүлэх боломжтой байна.

### **Анги танхимын эрүүл ахуйн үнэлгээ**

Сургуулийн эдэлбэр газар болон анги танхимын эрүүл ахуйн үнэлгээнд Завхан, Баянхонгор, Улаанбаатар хотын 26 сургуулийн нийт 74 анги танхимыг хамрууллаа.

Судалгаанд хамрагдсан сургуулиудын ахлах, дунд, бага анги тус бүрээс нэг ангийг санамсаргүйгээр сонгон тухайн ангид суралцаж буй нийт сурагчдын тоо, нэг хүүхдэд ноогдох талбай, ангийн агаарын хэм, харьцангуй чийглэг, байгалийн гэрэлтүүлэг, гэрэлтүүлгийн коэффициент, салхивчний талбайн харьцаа зэрэг үзүүлэлтүүдээр үнэлгээ өглөө.

Нэг хүүхдэд ноогдох талбайн дундаж хэмжээ  $1.55 \pm 0.49 \text{ м}^2$  байсан ба нийт ангийн 50 хувь нь стандартын шаардлага хангахгүй ( $1.5 \text{ м}^2$ -аас багагүй) орчинд хичээллэж байлаа. Хөтөлбөрийн орон нутгуудаар авч үзэхэд Дарь-Эхийн сургуулиудын 88.9%, Амгалангийн сургуулиудын 60%, Баянхонгорын сургуулиудын 57.1%, Завханы сургуулиудын 41.2%, Завхангайн сургуулиудын 8.3%-д нь нэг хүүхдэд ноогдох талбайн хэмжээ стандартаас бага байлаа.

Судалгаанд бага анги 24 (32.4%), дунд анги 28 (37.8%), ахлах анги 22 (29.7%) хамрагдсан. Анги танхимуудын агаарын дундаж хэм  $21.3 \pm 2.5$  байсан ба хамгийн өндөр нь  $26.74 \text{ C}^0$ , хамгийн бага нь  $14.96 \text{ C}^0$  хэмтэй байна.

Нийт анги танхимын 19 хувь нь стандартын шаардлага хангасан ( $18-20 \text{ C}^0$ ), 71 хувь нь стандартад заасан хэмжээнээс өндөр ( $20 \text{ C}^0$ -аас дээш), 10 хувь нь стандартаас бага ( $18 \text{ C}^0$  аас бага) агаарын хэмтэй анги танхимд хичээллэж байна.



Бага ангиудын 13.0, дунд ангиудын агаарын 20.8% ахлах ангиудын 23.8% нь л стандартын шаардлага хангасан ( $18\text{C}^0-20\text{C}^0$ ) анги танхимд хичээллэж байна. ОНХХ-өөр нь авч үзвэл Завханы сургуулиудын 31.3, Завхангайн сургуулиудын 58.3, Баянхонгорын сургуулиудын 5.6, Амгалангийн сургуулиудын 15.4 хувь тус тус нь стандартын шаардлага хангасан агаарын хэм бүхий анги танхимд хичээллэж байсан бол Дарь эхийн ОНХХ-ийн сургуулиудын анги танхимын агаарын хэм стандартын шаардлага хангахгүй байна.

Анги танхимын харьцангуй чийглэгийн дундаж хэмжээ нь  $36.9\pm 11.6\%$ , хамгийн их нь 58.42%, хамгийн бага нь 12.3% байгаа ба нийт анги танхимын 45.1%-ийнх чийглэгийн хэмжээ нь стандартын шаардлага хангаж байсан бол 54.9 хувь нь шаардлага хангахгүй байлаа.

Чийглэгийн хувьд бага ангиудын 54.2%, дунд ангиудын 34.6%, ахлах ангиудын 47.6% нь стандартын шаардлага (40-60%) хангаж байна. ОНХХ-р авч үзвэл Завханы сургуулиудын 25, Завхангайн сургуулиудын 41,7, Баянхонгорын сургуулиудын 61,9, Дарь-Эхийн сургуулиудын 77.8, Амгалангийн сургуулиудын 23.1 хувь нь тус тус стандартын шаардлага хангасан чийглэгтэй анги танхимд хичээллэж байна.

Анги танхимын гэрэлтүүлгийн хэмжээг анги тус бүрт 3 удаагийн хэмжилтийн дунджаар тооцон гаргалаа. Байгалийн гэрэлтүүлэгт үнэлгээ өгөхөд байгалийн гэрэлтүүлгийн коэффициент (БГК) ба гэрэлтүүлгийн коэффициентийг (ГК) ашигладаг. БГК нь 1.5-аас багагүй, ГК нь 4-6 байвал эрүүл ахуйн шаардлага хангаж байна гэж үздэг. Судалгааны анги танхимын 35.1 хувьд нь БГК хангалтгүй, 63.5 хувьд нь ГК хангалтгүй байна. Бага ангиудын 47.6, дунд ангиудын 26.9, ахлах ангиудын 47.4 хувьд нь БГК стандартын шаардлага хангахгүй байна. Хөтөлбөрийн орон нутгуудаар авч үзэхэд Завханы сургуулиудын анги танхимын 35.7, Завхангайн 41.7, Баянхонгорын 57.1, Амгалангийн 25 хувьд нь БГК-хангалтгүй байна.

ГК-г авч үзэхэд Завханы сургуулиудын 47.1, Завхангайн 41.7, Баянхонгор аймгийн 52.3, Дарь-Эхийн сургуулиудын 33.3, Амгалангийн сургуулиудын 45.5 хувьд нь ГК стандартын шаардлага (4-6) хангахгүй буюу бага байлаа.

Ангийн салхивчний хэмжээг шалны талбайд харьцуулсан харьцаа тавины нэгээс (1/50) багагүй байх ёстой байдаг. Ангиудын агааржуулалтын байдалд салхивчний хэмжээ хангалттай (1/50) байгаа эсэхийг үнэлэхэд ангиудын 4.6% хувьд нь салхивчны хэмжээ хангалтгүй байна.

Хөтөлбөрийн орон нутгуудаар авч үзэхэд Амгалангийн сургуулиудын 81.8, Дарь-Эхийн сургуулиудын 77, Завхан, Завхангай, Баянхонгорын сургуулиудын 23.5 хувьд нь тус тус салхивчны хэмжээ стандартын шаардлага хангахгүй байна.

## **Дүгнэлт**

Судалгаанд хамрагдсан сургуулиудын анги танхимын 81%-д нь агаарын хэм,  $\frac{1}{2}$  нь чийглэгийн хувьд эрүүл ахуйн шаардлага хангахгүй байна.

Нийт анги танхимын 35.1 хувьд БГК, 63.5 хувьд нь ГК хангалтгүй байна.

Нэг хүүхдэд ноогдох талбайн хэмжээгээр ангиудын тал хувь нь стандарт хэмжээнээс бага анги, танхимд хичээллэж байна.

Агааржуулалтын хувьд бүх анги танхим дахь агаарын хөдөлгөөний хурд стандартын шаардлага хангахгүй байна. Салхивчны хэмжээгээр хөдөө орон нутгийн сургуулиудын ¼ нь, Улаанбаатарын сургуулиудын 4/5 нь стандартын шаардлага хангахгүй байна

### **Гарыг арчдасны нян судлалын хурдавчилсан шинжилгээний дүн**

Судалгааны ажлын Зорилт 4-ын хүрээнд сурагчдын гарын ариун цэвэр, гар угаах дадалд үнэлгээ өгөхийн тулд 26 сургуулийн нийт 295 сурагчийн гарын арчдасанд гэдэсний бүлгийн савханцар илрүүлэх шинжилгээг хурдавчилсан тестийг ашиглан (SI тэжээлт орчин) хийлээ. Гарын арчдасыг үдийн цайны өмнө болон хичээл тарахын өмнөх цагуудад авсан ба асуумж судалгаанд хамрагдсан ахлах, дунд, бага ангиудийн сурагчдаас тэнцүү болон ойролцоо тоотойгоор сурагчдыг хамрууллаа.

Нийт 295 сурагчийн гарын арчдасны 40.4% (125) нь гэдэсний бүлгийн нянгаар бохирдсон байна. Үүнээс 59.2% нь гэдэсний бүлгийн нянгийн бага бохирдолтой, 40.8% нь гэдэсний бүлгийн нянгийн их бохирдолтой байлаа.

Улаанбаатар хотын сургуулиудаас нийт 121 сурагчийн гарын арчдасанд шинжилгээ хийсэн нь нийт арчдасын 41%-ийг эзэлж байсан ба тэдгээрийн 50.4%- нь гэдэсний бүлгийн нянгийн бохирдолтой гарсан байна.

Дарь-Эх ОНХХ-ийн сурагчдын 44.7% (21) нь нянгийн бохирдолтой байсан бөгөөд сургуулиар авч үзвэл 79 дүгээр сургуулийн 56.3, 48 дугаар сургуулийн 31.3, 102 дугаар сургуулийн 46.7 хувь нь тус тус гэдэсний бүлгийн нянгаар бохирлогдсон дүн гарчээ.

Судалгаанд хамрагдсан Амгалан ОНХХ-ийн сурагчдын 54.1% нь гэдэсний бүлгийн нянгийн бохирдолтой гарсан байна. Сурагчдын гарын арчдасны дүнгээр 27 дугаар сургууль хамгийн их бохирдсон үзүүлэлттэй байсан нийт арчдасны 75% нь гэдэсний бүлгийн нянгаар бохирлогдсон байлаа. Харин 87 дугаар сургуулийн сурагчдын гарын арчдасны 73.3, 92 дугаар сургуулийн 46.7, 68 дугаар сургуулийн 36.8, 120 дугаар сургуулийн 33 хувь нь тус тус бохирдолтой гарсан байв.

Баянхонгор аймгийн нийт 70 сурагчийн гарын ариун цэвэрт үнэлгээ өгснөөс 31.4 (22) хувь нь гэдэсний бүлгийн нянгийн бохирдолтой гарсан байна. Өлзийт сумын Сайн-Оюут сургуулийн сурагчдын гарын арчдасанд гэдэсний бүлгийн нянгийн бохирдол илрээгүй. Харин Баянхонгор сумын Эрдэм сургуулийн сурагчдын гарын арчдасны 57.0 хувь нь гэдэсний бүлгийн нянгаар бохирлогдсон буюу бусад сургуулиудтай харьцуулахад хамгийн их бохирдолтой гарсан байна. Харин Баянхонгор аймгийн бусад сургуулийн хувьд Номуундалай сургуулийн сурагчдын гарын арчдасны 12.5, Номгон сургуулийн 55.6, Эндэнэмандал сургуулийн 33.3, Soogo Seiko сургуулийн 22.2, Баян ойт сургуулийн 40.0, Эрдэнэцогт сумын Цогт-Эрдэм сургуулийн 50.0 хувь нь тус тус гэдэсний бүлгийн нянгаар бохирлогдсон үзүүлэлттэй гарчээ.

Завхан аймгийн хувьд нийт 104 сурагчийн гарын арчдасанд үнэлгээ хийснээс 40.4 (42) хувьд нь гэдэсний бүлгийн нянгийн бохирдол илэрсэн байна.

Үүнээс Завхан ОНХХ-ийн сургуулиудын нийт 63 сурагчаас гарын арчдасанд шинжилгээ хийхэд 36.5(23)хувь нь гэдэсний бүлгийн нянгийн бохирдолтой гарсан байна. Улиастай сумын Чандмань сургуулийн сурагчдын гарын арчдасанд хамгийн

бага (13.3%) бохирдол илсэрсэн бол Отгон сумын сурагчдын хамгийн их (75,0%) бохирдолтой гарсан байна.

Бусад сургуулийн хувьд авч үзэхэд Улиастай сумын Дэвшил сургуулийн арчдас авсан сурагчдын 20, 4-р сургуулийн 25.0, 3-р сургуулийн 50.0, Шилүүстэй сумын сургуулийн 71,4 хувьд нь тус тус гэдэсний бүлгийн нян илэрчээ.

Завхангай ОНХХ-ийн сурагчдаас нийт 41 сурагчийн гарын арчдасанд үнэлгээ өгөхөд 46.3(19) хувь нь гэдэсний бүлгийн нянгаар бохирлогдсон байна. Тосонцэнгэл сумын 2 дугаар сургуулийн сурагчдын гарын арчдасны 71,4 хувь бохирдолтой гарсан ба энэ нь бусад сургуультай харьцуулахад хамгийн өндөр үзүүлэлт байлаа. Тосонцэнгэл сумын 1 дүгээр сургуулийн сурагчдын 50.0, Улиастай сумын Жавхлант сургуулийн 46,2, Их уул сумын сургуулийн 30,8 хувь нь тус тус гэдэсний бүлгийн нянгийн бохирдолтой гэсэн үзүүлэлттэй гарчээ.

## **Дүгнэлт**

Судалгаанд хамрагдсан нийт сурагчдын 42 хувь нь гарын арчдасны шинжилгээгээр нянгийн бохирдолтой байна. Улаанбаатар хотын сургуулиудын сурагчдын 50.4 хувь, Завханы сургуулиудын сурагчдын 40.4 хувь, Баянхонгор аймгийн сургуулиудын сурагчдын 31.4 хувь нь гарын арчдасны шинжилгээгээр нянгийн бохирдолтой гарсан байна.

Завхан аймгийн сургуулиудаас Улиастайн Чандмань сургуулийн сурагчдын гарын бохирдол хамгийн бага гарсан байна. Чандмань сургууль нь төвлөрсөн шугамд холбогдсон сургууль байснаас харахад сургуулийн ус хангамж, хүртээмжийн асуудал хүүхдийн гарын ариун цэвэрт шууд нөлөөлдөг болох нь харагдаж байна.

## **2. Чанарын судалгааны үр дүн**

Чанарын судалгааг ганцаарчилсан болон бүлгийн ярилцлага хэлбэрээр явууллаа.

**Зорилго.** Чанарын судалгаагаар сургуулийн ус хангамж, ариун цэврийн байгууламжийн талаарх оролцогчдын үзэл бодлыг сонсож, тулгамдаж буй асуудлуудыг илрүүлэн, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэлийг тодорхойлох зорилго тавьсан.

### **Судалгааны арга зүй.**

Судалгааны зорилго, зорилтын хүрээнд урьдчилан боловсруулсан удирдамжийн дагуу сургуулийн ус хангамж, ариун цэврийн байгууламж, сургуулийн орчинд гар угаах боломж бүрдсэн эсэх, эрүүл мэндийн хичээлийг хэрхэн үр дүнтэй явуулах зэрэг сэдвүүдийн дагуу ярилцлагыг хөтлөн явууллаа.

Ярилцлагыг гүйцэтгэсэн байдал:

Ярилцлагыг туршлагатай бэлтгэгдсэн судлаач-чиглүүлэгч удирдан, ярилцлагын бичлэгийг дуу хураагуур ашиглан тэмдэглэн явууллаа.

Ярилцлагыг дараах үе шатаар явууллаа. Үүнд:

- Танилцуулга (5 мин) –Чиглүүлэгч ярилцлагын зорилго, ярилцах асуудлууд, хүн бүрийн санаа бодлыг сонсох сонирхолтой байгаа талаар болон оролцогчдыг чөлөөтэй ярих боломжоор хангалаа.
- Үндсэн ярилцлагын хэсэг (50-70 мин)- Ярилцлага чиглүүлэгч нь ярилцлагыг сэдвүүдийн дагуу гол асуултуудад чиглүүлэн оролцогчдын санал бодлыг сонслоо.

- Ярилцлагын төгсгөл хэсэг(10 мин) - Чиглүүлэгч ярилцлагын явцад гарсан зөвшөөрсөн болон үл зөвшөөрсөн асуудлуудын талаарх санаа бодол, зарим нэг хэв маяг болон зөвлөмжийг нэгтгэн танилцуулж, оролцогчдоос нэмж хэлэх зүйл байгаа эсэх талаар тодруулан талархал илэрхийлж ярилцлагыг дуусгалаа.

### Бүлгийн ярилцлагын үр дүн

Ярилцлагыг 3 бүлгээр 6-8 хүүхэд оролцуулж зохион байгуулав. Нийт 244 сурагч хамруулан 31 ярилцлага хийлээ (Хүснэгт 2). Ярилцлага бүрт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд 1-2 хамрууллаа.

1. Ахлах ангийн охидууд
2. Бага ангийн хүүхдүүд-эрэгтэй эмэгтэй нийлсэн бүлэг
3. Дунд ахлах ангийн нийлсэн бүлэг, эрэгтэй эмэгтэй

Хүснэгт 2

### Чанарын ярилцлагын тоо

	Ярилцлага зохион байгуулсан ОНХХ	Хамрагдсан сургууль	Ярилцлагад хамрагдсан бүлэг	Ярилцлагын тоо
1	Завхан	4-р сургууль	Ахлах ангийн охидууд, Дунд ахлах нийлсэн бүлэг, Бага анги	12
		3-р сургууль	Ахлах ангийн охидууд, Дунд ахлах нийлсэн, Бага анги	
		Шилүүстэй сум	Ахлах ангийн охидууд, Дунд ахлах нийлсэн, Бага анги	
		Отгон сум	Ахлах ангийн охидууд, Дунд ахлах нийлсэн, Бага анги	
2	Завхангай	2 дугаар сургууль	Ахлах ангийн охидууд, Дунд ахлах нийлсэн, Бага анги	5
		Тосонцэнгэл	Дунд ахлах нийлсэн	
		Их уул сум	Дунд ахлах нийлсэн	
3	Баянхонгор	Номгон сургууль	Дунд ахлах нийлсэн бүлэг	7
		Эрдэнэцогт сум	Ахлах ангийн охидууд, Дунд ахлах нийлсэн, Бага анги	
		Өлзийт сум	Ахлах ангийн охидууд, Дунд ахлах нийлсэн, Бага анги	
4	УБ хотын Дарь эх	102-р сургууль	Ахлах ангийн охидууд, Дунд ахлах нийлсэн, Бага анги	4
		48-р сургууль	Ахлах ангийн охид	
5	УБ хотын Амгалан	87-р сургууль	Ахлах ангийн охидууд, Дунд ахлах нийлсэн, Бага анги	3

### Дүгнэлт

Сургуулийн орчинд сурагчдын ундны цэвэр ус уух нөхцөл бололцоо хангагдаагүй байна. Ихэнх хүүхэд ам цангасан үедээ ус ууж чадахгүй байна.

Багш нар нь анхаарал хандуулдаг, үдийн цай хөтөлбөрт хамрагддаг учраас бага ангийн хүүхдүүд ахлах, дунд ангийнхаас илүү гараа угаадаг байна.

Хүүхдүүдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн бие засах газартай сургууль байхгүй байна. Гадаа бие засах газартай сургуулиудийн ихэнх нь хаалгагүй, хаалга нь дотроосоо цоожгүй, битүүмжлэл муутай байгаа нь хүүхдүүдэд таагүй сэтгэгдэл төрүүлдэг байна.

Эрүүл мэндийн хичээлээр хүүхдүүд тэдний хэрэгцээ, шаардлагад нийцсэн эрүүл ахуйн мэдээллүүдийг авч чадахгүй байна.

### **Ганцаарчилсан ярилцлагын үр дүн**

Ганцаарчилсан ярилцлагаар сургуулиудын ус хангамж, ариун цэврийн байгууламжийн одоогийн түвшин, ус хангамж, ашиглалтыг сайжруулах талаар авч хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, шийдвэрлэх арга замуудын талаар ярилцлаа. Ганцаарчилсан ярилцлагад судалгаанд хамрагдсан сургуулиудын захирал, эмч, эрүүл мэндийн хичээлийн багш, аймаг, сумын эрүүл мэндийн төвийн мэргэжилтэн зэрэг 86 хүн оролцсон байна. Ярилцлагад оролцогсдын ус хангамж, ариун цэврийн байгууламжийн талаарх санаа бодлыг нэгтгэн харууллаа.

### **Дүгнэлт**

Ерөнхий боловсролын сургуулиудын хувьд ус, ариун цэвэртэй холбоотой хамгийн тулгамдаж буй зүйл нь гар угаагуур, бие засах газрын хүртээмжийн асуудал байна. Ихэнх сургуулиуд төвлөрсөн шугамд холбогдоогүй, зөөврийн устай, гадаа бие засах газартай байна.

Сурагчид ам цангасан үедээ сургууль дээрээ ундны цэвэр усаар хангагдаж чадахгүй ус дуталд өртөж байна. Сургуулиуд өөрсдийн нөөц, боломж, төсөл хөтөлбөрийн тусламжтай ус, ариун цэврийн зарим нэг асуудлуудыг шийдвэрлэгдэг ч энэ нь хангалтгүй байна.

Улаанбаатар хот болон Завханы сургуулиуд ус, ариун цэвэртэй холбоотой аян уралдаан зохион байгуулах, ус хангамж, гар угаах дадлыг хэвшүүлэх талаар санаачлагатай ажиллаж байна.

Баянхонгор аймгийн сургуулиудад сүүлийн 5 жил (2009-2012) вируст гепатит А тасралтгүй гарсан байна. Үүнд сургуулиудын сурагчдын тоо хэтэрсэн, ачаалал их, гэр хорооллын усны чанар муу, худаг, усан сан байхгүй зөөврийн устай, сургуулийн ариун цэврийн байгууламж хүртээмжгүй зэрэг олон хүчин зүйлүүд нөлөөлсөн байх боломжтой байна.

Эрүүл мэндийн хичээлийн цаг, хөтөлбөрийн агуулгад өөрчлөлт хийх шаардлагатай байна.

Дэлхийн өдрүүдийн хувьд Улаанбаатар, аймгийн төвийн сургуулиуд тодорхой хэмжээгээр тэмдэглэн өнгөрүүлдэг, энэ талаар мэдээлэлтэй байхад, зарим сумын сургуулиуд энэ талаар ямар ч мэдээлэлгүй байдаг байна.